

“ГОЛОМТ БАНК ХК” ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

/2023 оны 3 сарын 31-ний байдлаар/



ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлэх 103,317,524,755 төгрөгөөс үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн:

- Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлуудыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулна;
- Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт сайжирч эрсдэлээр жигнэсэн актив буюу зээлийн багцын хэмжээг ойролцоогоор 790 гаруй тэрбум төгрөгөөр өсгөх боломж бүрдэж, ирээдүйн бизнесийн тогтмол өсөлтийг бий болгох гол суурь болно.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Банк 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд анхдагч зах зээлийн арилжаагаар хувьцааныхаа 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,285 төгрөгөөр нийтэд санал болгов. Захиалгын эрэлт өндөр байсан тул олон нийтэд санал болгосон хувьцааны 15 хувьтай тэнцэх хэмжээний буюу 12,060,411 ширхэг хувьцааг нэмэлтээр гаргаж, нийт 118,815,152,890 төгрөгийг /нийт хувьцааны 11.43 хувь/ олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн 118,815,152,890 төгрөгийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардал: 2.1 тэрбум төгрөг

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 12 сарын 06-ны өдрийн 1/4659 тоот зөвшөөрлөөр 2022 оны 12 сарын 08-ны өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төвөөр дамжин нийт 118,815,152,890 төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс СТОУС дагуу үнэт цаас гаргахтай шууд хамаарал бүхий зардлыг ААНОАТ-ын дүнгээр цэвэршүүлэн 2,103,028,206 төгрөгийг хасагдуулж цэвэр 116,712,124,684 төгрөгөөр банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн.

2. Зээл олголт: 31.0 тэрбум төгрөг

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт /Монголбанкны тайлангаар/

Үзүүлэлт (сая төгрөг)	11/30/2022	12/31/2022	3/31/2023	Өөрчлөлт (3/31/2023-11/30/2022)	
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	673,839	811,978	845,640	171,801	25%
Өөрийн хөрөнгө (Ө.Х)	673,839	811,978	845,640	171,801	25%
Эрсдэлээр жигнэсэн актив	4,600,320	4,601,535	4,833,930	233,610	5%
/ зэрэглэлийн Ө.Х-ийн хүрэлцээ (>9.0%+нөөц 4.0%)	14.65%	17.65%	17.49%	2.85%	
Нийт Ө.Х-ийн хүрэлцээ (>12.0%)	14.65%	17.65%	17.49%	2.85%	

2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөртэй харьцуулахад банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцох нийт өөрийн хөрөнгө 171.8 тэрбум төгрөгөөр /татан төвлөрүүлсэн хөрөнгө болон цэвэр ашгаар/ буюу 25 хувиар өсөж 845.6 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх хугацаанд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 2.85 нэгж хувиар нэмэгдэж банкны эрсдэл даах чадвар сайжирсанаар зээлийн багцын хэмжээг өсгөх боломж бүрдсэн.

Банк 2022/12/09-өөс 2023/03/31-ны хооронд харилцагчдад нийт 2,087.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу эрсдэлтэй активын хамгийн багадаа 13 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай байдаг. Нийт өөрийн хөрөнгийн 11.43 хувийг олон нийтэд нээлттэй хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө эзэлж байх тул дээрх хугацаанд шинээр олгосон зээлийн 31 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн 31.0 тэрбум төгрөгийн зээлийг төлөвлөгөөний дагуу Том аж ахуйн нэгжийн бизнесийн зээлд 11.5 тэрбум /37.3 хувь/, ЖДБ болон иргэдэд олгосон бизнесийн зээлд 8.1 тэрбум /26.0 хувь/, Хэрэглээний зээлд 6.4 тэрбум /20.7 хувь/, Орон сууцны зээлд 5.0 тэрбум /16.0 хувь/ бүтцээр олгоод байна.

3. Ашиглагдаагүй нөөц: 85.7 тэрбум төгрөг

Одоогийн байдлаар ашиглагдаагүй 85.7 тэрбум төгрөгийг Монголбанкны үнэт цаасанд байршуулсан бөгөөд цаашид төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар зээл олголтыг санхүүжүүлнэ.